



НИЙСЛЭЛИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ТОГТООЛ

2024 оны 06 сарын 18 өдөр

Дугаар 87

Улаанбаатар хот

“Бэлчээрийн менежмент төслийн нэгж”  
орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрыг  
татан буулгах тухай

Монгол улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.12 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.1 дэх заалт, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 77 дугаар зүйлийн 77.2.4 дэх заалтыг тус тус үндэслэн Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас ТОГТООХ нь:

1.“Бэлчээрийн менежмент төслийн нэгж” орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрыг 2024 оны II улиралд багтаан татан буулгасугай.

2.Дээрх орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын баланст бүртгэлтэй 2,527,013,165.36 (хоёр тэрбум таван зуун хорин долоон сая арван гурван мянга нэг зуун жаран таван төгрөг гучин зургаан мөнгө) төгрөгийн өртөг бүхий хавсралтад дурдсан хөрөнгийг балансаас баланст шилжүүлэх, өр авлагын асуудлыг шийдвэрлэж, холбогдох арга хэмжээг авч ажиллахыг Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч (Х.Нямбаатар)-д үүрэг болгосугай.

3.Тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хурлын Эдийн засаг, төсвийн хороо (М.Халиунбат)-нд даалгасугай.

ДАРГА



Ж.БАТБАЯСГАЛАН

Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын  
2024 оны 06 дугаар сарын 18-ны  
өдрийн 87 дугаар тогтоолын хавсралт

**“БЭЛЧЭЭРИЙН МЕНЕЖМЕНТ ТӨСЛИЙН НЭГЖ” ОНӨТҮГ-ЫН  
БАЛАНСААС БАЛАНСТ ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГИЙН ЖАГСААЛТ**

№	Үзүүлэлт	Санхүү байдлын тайланд тусгагдсан дүн	
		Балансын үнэ	Хуримтлагдсан элэгдэл
1	Барилга байгууламж	909,854,256.00	77,132,512.61
2	Тээврийн хэрэгсэл	563,363,658.00	381,687,057.12
3	Машин, тоног төхөөрөмж	627,438,763.96	401,032,122.33
4	Тавилга, эд хогшил	30,671,597.00	27,145,833.41
5	Бусад үндсэн хөрөнгө	321,197,562.40	147,561,220.41
6	Биет бус хөрөнгө	5,975,000.00	5,608,333.22
7	Мал амьтан	68,512,328.00	
<b>ХӨРӨНГИЙН НИЙТ ДҮН</b>		<b>2,527,013,165.36</b>	<b>1,040,167,079.10</b>